

| | |
|---------------------------------------------------------------------------------------|----|
| ОРШИЛ | 3 |
| НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ | 4 |
| ХОЁР. УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ, АЖИЛЛАХ ГОРИМ, КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ | 13 |
| 2.1. Уурхайн ажиллах горим..... | 13 |
| 2.2. 2018 оны уулын ажлын төлөвлөгөөний биелэлт /2018.11.01/ | 14 |
| 2.3. Уурхайн тээвэр | 32 |
| ГУРАВ. УУРХАЙН ТЭЭВРИЙН МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ | 35 |
| 3.1. 2018 оны техникүүдийн техник ашиглалтын өнөөгийн байдал /11-р сарын 01/..... | 35 |
| ДӨРӨВ. ОВООЛГЫН АЖ АХУЙ..... | 40 |
| 4.1. 2018 оны овоолгын аж ахуйн гүйцэтгэл | 40 |
| ТАВ. УУРХАЙН УС ШҮҮРҮҮЛЭЛТ..... | 41 |
| 5.1. Уурхайн ус шүүрүүлэлтийн өнөөгийн байдал | 41 |
| 5.2. 2018 онд шавхсан усны хэмжээ, цооног ашиглалтын мэдээ | 41 |
| 5.3. Уурхайн (үйлдвэр) ус хангамж, усны сав газар | 44 |
| ЗУРГАА. ХӨРСНИЙ ХАГАРАЛ, СУУЛТ | 45 |
| 6.1. Хагарал суултын төхцөл байдал..... | 45 |
| 6.2.Хагарал суултын байдлыг хянах зорилгоор авсан эхний арга хэмжээ | 45 |
| ДОЛОО. УУРХАЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ..... | 52 |
| 7.1. Цахилгаан хангамж | 52 |
| НАЙМ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ | 53 |
| 8.1. 2018 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт..... | 53 |
| 9.1.1. Сэрэг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 53 |
| 9.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт..... | 55 |
| 9.3. Техникийн нөхөн сэргээлт..... | 56 |
| 9.4. Биологийн нөхөн сэргээлт | 66 |
| 9.5. Нөхөн сэргээлтийн ажлын зардал | 67 |
| ЕС. Байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөний биелэлт..... | 78 |
| АРАВ. ХАВСРАЛТУУД..... | 83 |

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

| | |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Зураг №01 Судалгааны талбайн ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн зураг..... | 5 |
| Зураг №02 Судалгаанд хамрагдсан газрын байршлын зураг..... | 8 |
| Зураг №03 Шивээ-Овоогийн нүүрсний ордын бүрэлдэхүүн хэсгүүд, дэд бүтцийн байдал..... | 9 |
| Зураг №04 Агаарын дундаж температурын жилийн явц..... | 10 |
| Зураг №05 Хөрс газарзүйн мужлал, талбайн байршил..... | 12 |
| Зураг №06. ЭКГ5А экскаваторын технологийн паспорт..... | 17 |
| Зураг №07 Гидроэкскаваторуудын ажиллах паспорт | 21 |
| Зураг №08 Дугуйт ачигчийн ажиллах паспорт | 22 |
| Зураг №09 ЭШ-25/90 Алхагч экскаваторын ажиллах схемийн зүсэлт..... | 26 |
| Зураг №10 ЭШ-11/70 Алхагч экскаваторын ажиллах схемийн зүсэлт..... | 28 |
| Зураг №11 Нүүрс тээвэрлэлтийн схем | 33 |
| Зураг №12 Технологийн автомашины замын паспорт | 34 |
| Зураг №13 Овоолгийн паспорт..... | 40 |
| Зураг №14 Хяналтын хэмжилт график..... | 46 |
| Зураг №15 Хяналтын хэмжилт график..... | 46 |
| Зураг №16 Уурхайн олборлолтын бүсийн гадна овоолгод үүссэн хагарал суултыг харуулсан дэвсгэр зураг..... | 46 |
| Зураг-17. Уурхайн хагарал суулт өгсөн талбайн 3D дэвсгэр зураг..... | 47 |
| Зураг-18. Хагарал, суултын бүсийн хайгуулын шугамын зүсэлт зураг..... | 47 |
| Зураг-19. Уурхайн хагарал суултын идэвхижилттэй бүсийн хяналтын 25 цэгийг харуулсан талбайн 3D дэвсгэр зураг..... | 48 |
| Зураг-20. Хяналтын 25 цэгийн 8-р цэгийн хэмжилтын мэдээлэлийн график..... | 49 |
| Зураг-21. Гулсалтыг зогсоох үүднээс тулгуур мост хийж хэрэгжүүлэлт хийгдэж байгаа 3D дэвсгэр зураг..... | 50 |
| Зураг-22. Нөхөн сэргээлт хийсэн талбай зураг..... | 57 |
| Зураг-23. Шимт хөрс хуулсан талбайн дэвсгэр зураг..... | 58 |

ОРШИЛ

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1989 оны 04-р сарын 26-ны өдрийн 98 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 1989 оны 05-р сарын 24-ны өдөр ЭХУУҮГ Яамны сайдын 134 дүгээр тушаал гарч Шивээговь хотхоны хамгаалалт, ашиглалтын түр захиргаа байгуулахаар шийдвэрлэсэн нь өнөөдрийн Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үндэс суурь болжээ.

Жилдээ 500.0 мян.тн нүүрс олборлон борлуулах хүчин чадалтай уурхай байхаар анхны зураг төсөл нь батлагдаж улмаар уурхайн амыг 1990 оны 07-р сарын 31-ны өдөр нээсэн билээ. Энэ өдрөөс хойш 5-н сарын хугацаанд 770.0 мян.м3 хөрс хуулж, 1991 оны 12-р сарын 23-ны өдөр анх нүүрсээ олборложээ. 1993 онд техникийн шинэчилэл хийгдэж төслийн хүчин чадлаа эзэмшсэн.

Монгол улсын Засгийн газраас тус уурхайг хувьчлах шийдвэр гаргасан нь 1995 оны 09-р сарын 12-ны өдөр “Шивээ-Овоо ХК”-ийг байгуулав. Нийт дүрмийн сангийн 90%-ийг төр, 10%-ийг хувь нийлүүлэгчид эзэмшдэг.

Нүүрсний салбарыг хөгжүүлэх “Мастер төлөвлөгөө”-ний хүрээнд 1998 онд Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр уурхайн техник, технологийг шинэчлэх төсөл хэрэгжиж эхэлсэн одоогийн байдлаар тус уурхай жилдээ 4.6 сая.м3 хөрс хуулж, 2.0 сая.тн нүүрс олборлох хүчин чадалтай болсон байна. Шивээ-Овоогийн ордын нүүрс нь Х-3 бүлгийн хүрэн нүүрсний ангилалд хамаарах ба одоогийн байдлаар Монгол улсын дотоодын нүүрсний хэрэгцээний 30.0%, “ДЦС-4” ТӨХК-ийн хэрэгцээний 50.9%-ийг дангаараа хангаж байна.

Тус уурхай нь 2018 оны 11-р сарын 01-ний байдлаар 30.2 сая.тн нүүрс олборлон, 29.9 сая.тн нүүрс хэрэглэгчдэд нийлүүлэн, 28.4 сая.м3 тээвэргүй хөрс хуулалт, 73.1 сая.м3 тээвэртэй хөрс хуулалт, 20.0 сая.м3 дахин шидэлт, инженер ажил хийж нийт 146.5 сая.м3 уулын цулын ажил гүйцэтгээд байна.

2019 онд техник, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа буурсан, хөрс хуулалтын хоцрогдол нэмэгдэж байгаа нөхцөл байдлаас хамааруулж шаардлагатай техникүүдийн хөрөнгө оруулалтаар хөрс хуулалтын ажлыг нэмэгдүүлэн гүйцэтгэхээр уулын ажлын төлөвлөгөөг боловсруулсан.

Хөрс хуулалтын ажил нэмэгдэж уурхайн гүн 100 гаруй метрт хүрч мөн хөрсний хоцрогдол үүссэн байдлыг бууруулах дотоод овоолгийн ачааллыг удирдах арга хэмжээний хүрээнд автотээвэр хосолсон хөрсний конвейерийн шаардлагыг тодорхойлох 2020 онд ашиглалтанд оруулахаар тусгах бэлтгэл ажлыг гүйцэтгэх зэргээр боловсруулав.

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Шивээ-Овоогийн уурхайн газар зүйн товч тодорхойлолт

Шивээ-Овоогийн орд нь Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт, аймгийн төв Чойр хотоос зүүн урагш 20 км, Улаанбаатараас зүүн урд зүгт 260 км зайнд оршдог.

Тус ордод Төвийн геологийн экспедици 1986-1988 онуудад урьдчилсан ба нарийвчилсан хайгуул хийсэн байна. Шинэ-Усны хэсгийн хил нь баруун талаараа Чойр-Сайншандын төмөр зам, зүүн талаараа нүүрсний I давхаргын гарш, өмнөд талаараа хайгуулын 3-р хөндлөн шугамаар хязгаарлагддаг. Гадаргуу нь дов толгодорхог, далайн түвшнээс дээш 1180-1230 м өргөгдсөн бөгөөд дов толгодыг элсэн чулуу, бялхмал ба гүний чулуулгуудын илэрцүүд үүсгэдэг.


Ордын нийт нөөц 2,7 тэрбум тонн, үүнээс 665,4 сая тонн нийт нөөцийг 1988 онд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлаар Шинэ-Усны хэсэгт тогтоосон байдаг. Өнөөдрийн байдлаар стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордын тусгай зөвшөөрлүүдийг дараах 3 хуулийн этгээд эзэмшиж байна (Хүснэгтээс харах). Стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчид

Хүснэгт-№01

| д/д | Тусгай зөвшөөрлийн эзэмшил | Тусгай зөвшөөрөл бүхий талбайн нэр | Тусгай зөвшөөрлийн дугаар | Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ/га |
|-----|----------------------------|------------------------------------|---------------------------|--------------------------------------|
| 1 | “ШИВЭЭ-ОВОО” ХК | Шивээ-Овоо | 901А | 91 |
| 2 | "ЭРДЭНЭС МГЛ" ХХК | Талбай-1 | 13311А | 2784.0 |
| 3 | "ЭРДЭНЭС МГЛ" ХХК | Талбай-2 | 13312А | 1239 |
| 4 | "ЭРДЭНЭС МГЛ" ХХК | Талбай-3 | 13313А | 270 |
| 5 | “ЭЙКҮСОРА” ХХК | Шивээговь-1 | 8294Х | 7115 |
| 6 | “ЭЙКҮСОРА” ХХК | Хүрэн дух | 8296Х | 22373 |
| 7 | “ЭЙКҮСОРА” ХХК | Шивээговь | 8297Х | 596.09 |
| 8 | “ЭЙКҮСОРА” ХХК | Шивээ-2 | 8829Х | 737 |
| 9 | “ЭЙКҮСОРА” ХХК | Шивээ-1 | 8830Х | 501 |
| 10 | “ЭЙКҮСОРА” ХХК | Шивээ-2 | 13250Х | 691 |
| 11 | “ЭЙКҮСОРА” ХХК | Шивээ-1 | 13251Х | 468 |

1990 оны 07-р сарын 31-ны өдөр Шивээ-Овоогийн уурхайн амыг нээснээр ашиглалтанд орсон түүхийн үе эхэлдэг. Шивээ-Овоогийн уурхай нь 1991 оны 12-р сарын 23-ны өдөр анхны нүүрсээ олборлож, 1995 оны 9 дүгээр сарын 22 нд “Шивээ-Овоо” ХХК болж өргөжжээ. Нийт хувьцааны 90%-ийг Төр эзэмшдэг бөгөөд 10%-ийг хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. Мөн Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордын Шинэ-Усны хэсгийн 4290 га талбайд төрийн өмчит “Эрдэнэс МГЛ” ХХК тусгай зөвшөөрөлтэй (ТЗ) үйл ажиллагаа явуулж байна. Шивээ-Овоогийн ордын хүрэн нүүрсний ордын бусад хэсгүүдэд “ЭЙКУСОРА” ХХК тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

Хайгуулын талбайн физик газарзүйн байрлал. 1980-аад оны сүүлээс Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордын хэмжээнд хайгуулын ажил эхэлж байсан бөгөөд тухайн үед уг орд нь Дорноговь аймгийн Сүмбэр сумын нутагт харьяалагдаж байсан ч одоогийн засаг захиргааны нэгжийн шинэчилсэн хувиарлалтаар Говьсүмбэр аймгийн нэг сум болжээ. Уг орд нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумаас (төмөр замын Чойр өртөө) зүүн-өмнө зүгт 20км-т, Чойр-Нялгын нүүрсний сав газрын зүүн-хойд хэсгийг эзлэн байршина (Зураг.1).



Зураг-1 Судалгааны талбайн ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн зураг

Стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний орд дээрх “Шивээ -Овоо” ХХК-ний эзэмшиж байгаа 901А тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн цэгүүдийн солбицлууд:

Хүснэгт-№02

| Д/д | Байгууллагуудын нэр | Цэгүүд/ дугаар | Газарзүйн солбицол | |
|-----|---------------------|----------------|------------------------|-------------------------|
| | | | Уртраг град мин сек | Өргөрөг град мин сек |
| 1 | Шивээ-Овоо ХК | 1 | 108 32 27 | 46 13 05 |
| 2 | Шивээ-Овоо ХК | 2 | 108 32 27 | 46 13 32 |
| 3 | Шивээ-Овоо ХК | 3 | 108 31 45 | 46 13 32 |
| 4 | Шивээ-Овоо ХК | 4 | 108 31 45 | 46 13 17 |
| 5 | Шивээ-Овоо ХК | 5 | 108 31 25 | 46 13 17 |
| 6 | Шивээ-Овоо ХК | 6 | 108 31 25 | 46 13 05 |

Стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний орд дээрх “Эрдэнэс МГЛ” ХХК-ний эзэмшиж байгаа 13311А тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн цэгүүдийн солбицлууд:

Хүснэгт-№03

| Д/д | Байгууллагуудын нэр | Цэгүүд/ дугаар | Газарзүйн солбицол | |
|-----|---------------------|----------------|------------------------|-------------------------|
| | | | Уртраг град мин сек | Өргөрөг град мин сек |
| 1 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 1 | 108 30 31 | 46 13 49.36 |
| 2 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 2 | 108 30 31 | 46 13 54 |
| 3 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 3 | 108 31 36 | 46 13 54 |
| 4 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 4 | 108 31 36 | 46 15 19 |
| 5 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 5 | 108 36 41 | 46 15 19 |
| 6 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 6 | 108 36 41 | 46 13 05 |
| 7 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 7 | 108 32 27 | 46 13 05 |
| 8 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 8 | 108 32 27 | 46 13 32 |
| 9 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 9 | 108 31 45 | 46 13 32 |
| 10 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 10 | 108 31 45 | 46 13 17 |
| 11 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 11 | 108 31 25 | 46 13 17 |
| 12 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 12 | 108 31 25 | 46 13 05 |
| 13 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 13 | 108 31 08 | 46 13 05 |
| 14 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 14 | 108 30 45 | 46 13 23 |

Стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний орд дээрх “Эрдэнэс МГЛ” ХХК-ний эзэмшиж байгаа 13312А тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн цэгүүдийн солбицлууд:

Хүснэгт-№04

| Д/д | Байгууллагуудын нэр | Цэгүүд/ дугаар | Газарзүйн солбицол | |
|-----|---------------------|-------------------|------------------------|-------------------------|
| | | | Уртраг град мин сек | Өргөрөг град мин сек |
| 1 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 1 | 108 31 08 | 46 13 05 |
| 2 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 2 | 108 36 41 | 46 13 05 |
| 3 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 3 | 108 36 41 | 46 12 06 |
| 4 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 4 | 108 33 40 | 46 12 06 |
| 5 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 5 | 108 33 40 | 46 11 29 |
| 6 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 6 | 108 33 24.81 | 46 11 29 |

Стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний орд дээрх “Эрдэнэс МГЛ” ХХК-ний эзэмшиж байгаа 13313А тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн цэгүүдийн солбицлууд:


Хүснэгт-№05

| Д/д | Байгууллагуудын нэр | Цэгүүд/ дугаар | Газарзүйн солбицол | |
|-----|---------------------|-------------------|------------------------|-------------------------|
| | | | Уртраг град мин сек | Өргөрөг град мин сек |
| 1 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 1 | 108 30 31 | 46 12 43.89 |
| 2 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 2 | 108 32 19.81 | 46 11 29 |
| 3 | “Эрдэнэс МГЛ” ХХК | 3 | 108 30 31 | 46 11 29 |

Улаанбаатар-Сайншандыг холбосон төмөр зам болон засмал магистраль замууд нь “Эрдэнэс МГЛ” ХХК-ний эзэмшилд байгаа тусгай зөвшөөрлийн гурван талбайнууд, Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордын нүүрсний нөөцтэй талбай дээгүүр шууд нэвтрэх бөгөөд тус ордын үйлдвэрлэлийн ихэнх нөөцийг агуулж байгаа Шинэ-Усны хэсэг нь төмөр замын магистралийн зүүн хойд хэсэгт бүхэлдээ байрладаг.



Зураг.2 Судалгаанд хамрагдсан газрын байршлын зураг



Зураг 3. Шивээ-Овоогийн нүүрсний ордын бүрэлдэхүүн хэсгүүд, дэд бүтцийн байдал

Газрын гадаргын хэлбэршлийн хувьд Чойр-Нялгын сав газар нь намхан уул толгодоор хүрээлэгдсэн зүүн талаараа дугуйрсан гадагшаа гарцгүй хотгор хөндий бөгөөд

түүнийг хүрээлж байгаа уул, толгод нь базальт, боржин гэх мэт галт уул, маагмын гаралтай гүний чулуулгууд, элсэнчулуу, гравелит, хөрзөн зэрэг хурдас хуримтлалын гаршаас бүрдэх ба тэдгээр уулсын үнэмлэхүй өндөр нь 1180-1230м-т хэлбэлзэнэ.

Дүүргийн хэмжээнд эх газрын эрс тэс уур амьсгалтай, зун нь халуун үргэлжлэх хугацаа богино, өвөл нь урт, хүйтэн -35° хүрдэг ба хөрсөндөө -40° хүрнэ.

Газрын хөрс өвөлдөө 2-4 м хүртэл гүн хөлдөх ба цасан бүрхүүл багатай хуурай байдаг. Салхины чиглэл үндсэндээ баруун хойноос зонхилох бөгөөд хурд нь 6,0-20,0 м/сек заримдаа 40,0 м/сек хүрэх тохиолдол байдаг.

Уур амьсгал. Шивээ-Овоогийн нүүрсний орд орчим нь Төв Азийн геоморфологийн их мужийн дорнод дэдмужид хамаардаг, гандуу дулаан зунтай, хүйтэн өвөлтэй, хээрийн бүсэд багтана. Цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг ордод хамгийн ойр байрлах Чойрын цагуурын станцын ажиглалтын материалд тулгуурлан авлаа. Уур амьсгалын гол хүчин зүйл болох агаарын температурыг авч үзвэл ордын байрлалын районд жилийн дундаж агаарын температур 2.3°C , хамгийн дулааны улирал болох 7 дугаар сарын агаарын дундаж температур 21.1°C , хамгийн хүйтэн 1 дүгээр сарын агаарын дундаж температур -19.3°C байна.

Орд орчмын агаарын дундаж температур (сар, жилээр)

Хүснэгт-№06

| Сар | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII | ж/д |
|-------------------------------|-------|-------|------|-----|------|------|------|------|------|-----|------|-------|-----|
| Температур $^{\circ}\text{C}$ | -19,3 | -12,4 | -7,8 | 6.1 | 11,3 | 19,7 | 21,1 | 17,9 | 11,3 | 3,4 | -7,8 | -16,7 | 2,3 |



Зураг-4. Агаарын дундаж температурын жилийн явц

Эндээс үзэхэд хоногийн дундаж агаарын температур 00°C -ээс их байх хугацаа IV-X саруудад үргэлжилнэ. Нутгийн хойд, зүүн, төвийн хэсгээр 250 - 300 мм, баруун хэсгээр 200 - 250 мм, баруун өмнөд хэсгээр 150 - 200 мм тунадас унадаг. Хүйтний улиралд хойд хэсгээр 10-20 мм, өмнөд хэсгээр 5 – 10 мм, дулааны улиралд хойд хэсгээрээ 200 — 300 мм, өмнөд хэсгээрээ 100 - 200 мм тунадас дунджаар унадаг. Жилийн IX дүгээр сарын 20-оос XII дугаар сарын 1-ний хооронд тогтвортой цасан бүрхүүл үүсдэг. Цасан бүрхүүлийн дундаж зузаан 10 мм, дунджаар 3 дугаар сарын 1-ээс цасан бүрхүүл ханзарч эхлэх бөгөөд


тогтвортой цасан бүрхүүл 100 орчим өдөр үргэлжилнэ. Харин гуу жалга хотгор хэсгүүдэд цасны хучаасын зузаан 1 м хүртэл нэмэгддэг. Хавар эхлэнгүүт цас хайлж хөрсний доорх усыг тэжээдэг онцлогтой. Уур амьсгалын өөрчлөлтөд салхины хурд, хүчтэй салхитай өдрийн тоо, агаарын бохирдолт, тоосжилт гол гол нөлөө үзүүлдэг. Хүчтэй салхи гол төлөв IV-V саруудад тохиолддог байна. Тухайн бүсд 15 м/с ба түүнээс хүчтэй салхитай өдөр 10 - 20, жилд ойролцоогоор 5 өдөр цасан шуургатай байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд салхины хурд, хүчтэй салхитай өдрийн тоо, агаарын бохирдолт, тоосжилт зэрэгт гол нөлөө үзүүлдэг. Хүчтэй салхи гол төлөв IV-V саруудад тохиолддог байна. Тухайн бүсд 15 м/с ба түүнээс хүчтэй салхитай өдөр 10 - 20, жилд ойролцоогоор 5 өдөр цасан шуургатай байна.

| Зүгчиг | Х | ЗХ | З | ЗӨ | Ө | БӨ | Б | БХ |
|------------|----|----|---|----|---|----|---|----|
| Давтагдал% | 20 | 8 | 4 | 16 | 4 | 4 | 4 | 40 |

Ус зүй. Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордын талбайн хэмжээнд байнгын үйл ажиллагаатай усан сүлжээ байхгүй бөгөөд зөвхөн ширүүн аадар борооны болон цасны шар усны үерийн үед сэргэж дараа нь хатдаг хуурай сайр, тойрмууд хөгжсөн байдаг. Оршин суугчид нь унд усныхаа хэрэгцээг зөвхөн худгаас хангадаг.

Хөрс. Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутаг дахь “Эрдэнэс МГЛ” ХХК-ний 13311А, 13312А тусгай зөвшөөрөл бүхий талбайн байрлах нутаг дэвсгэр нь газар зүйн мужлалаар Хангайн их мужийн өргөргийн бүсшилийн Бүрд-Баянцагааны хүрэн хөрсний 3-р тойрог, Бор-өндөр-Уулбаяны 6-р тойргийн зааг, говийн их мужийн Баяндэлгэрийн цайвар хүрэн хөрсний 8-р тойргийн хойд хэсэгт хамрагддаг онцлогтой. Энэхүү тойрогт тал хөндийн цайвар хүрэн, /kastanozems/ хүрэн /aridic kastanozems/ хөрсний хэв шинжүүд тус тус тархана. (Монгол Улсын Үндэсний атлас, 2009).



Зураг-5. Хөрс газарзүйн мужлал, талбайн байршил

Хөрсний хээрийн судалгаагаар 13311А,13312А ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь ерөнхийдөө тэгшивтэр газрыг хамран байрлах бөгөөд далайн түвшинээс дээш 1188-1200 метрийн өндөрт орших тухайн эдэлбэр газарт дараахи үндсэн хэв шинж, дэд хэв шинж, төрөл, дүрсийн хөрс тархсан байдаг. Үүнд:

Нам уул толгодын цайвар хүрэн хөрс. Судалгаанд хамрагдсан талбайн нам уулс, толгодын хэсгээр нимгэн хүрэн хөрс тархах ургамлын нөмрөгт алаг өвс-үетэнт, үетэнт-алаг өвс, сөөгт бүлгэмдэл бүхий зүйлийн бүрдлээр ядуувтар, сийрэг ургасан хуурай хээрийн ургамалжил зонхилж газрын гадаргын 10-30%-ийг бүрхэнэ. Хөрс үүсгэгч эх чулуулаг нь гол төлөв делюви, элюви-делювийн гаралтай сайр чулуурхайг хурдас байна.

Сул хөгжилтэй элсэнцэр хүрэн хөрс. Хөрсний гадарга ямар нэгэн хэмжээгээр элсээр бүрхэгдсэн байх бөгөөд гандмал бордуу өнгөтэй, хялбар бутардаг, хэврэг нимгэн өнгөн үеэр эхэлнэ.

Далд глейрхэг хүрэн хөрс. Хүрэн хөрсний хил зааг дотор нам доор хэсгээр тархах ба ургамалжилт нилээн сайн байдаг онцлогтой.

Ургамлын аймаг. Эрдэнэс МГЛ ХХК-ий ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай орчим нь Монгол орны ургамал газар зүйн мужлалаар Евразийн хээрийн их мужийн Дундад халхын дэд мужид хамрагдана. /Монгол Улсын Үндэсний атлас 2009 он/. Судалгаанд хамрагдсан талбай нь нам хотос тэгшивтэр газар байна. Энд говь хээрийн ургамалжилт зонхилно. Зонхилох ургамал нь *Caragana microphylla*, *Stipa krilovii*, *Elymus chinensis*, *Artemisia frigid*, *Cleistogenes squarrosa*, *Carex duriscula* оролцоно. Шивээ-овоо орчимд дэрс-хялганат, хазаар өвс-хялганат, харгана-алаг өвс-шарилжит

бүлгэмдэлүүд тархана. Судалгааны объектийн бэлчээрийн хэв шинжийг бүрдүүлэгч төрлүүд нь ургамалын дундаж өндөр 8-25 см, ерөнхий бүтэц 30-40 хувь байх ба аж ахуйн бүлгээр нь ангилж үзэхэд үетэн 20, алаг өвс 35, буурцагтан 45 орчим хувийг эзэлж байна. Энд ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц нь 30-35% байна. Зонхилох ургамал нь *Stipa krilovii*, *Stipa gobica*, *Allium polyrrhizum*, *Artemisia frigida* оролцоно. Шивээгийн нүүрсний уурхайн орчимд *Caragana pugnata* бүхий сөөгт агь – таана хялганат бүлгэмдэл зонхилон тархаж байна. *Caragana pugnata* *Stipa gobica* *Allium polyrrhizum* *Cleistogenes squarrosa* *Agropyron cristatum* *Artemisia frigida* *Kochia prostrata* *Carex korshinskyi* зэрэг зүйл ургамлууд зонхилоно. Түүнчлэн Шивээ овоогийн нүүрсний уурхайн орчмын ургамлан нөмрөг хүн, машин механизмын нөлөөгөөр ургамлан бүрхэвч нэлээд их талхлагдсан. Зүйлийн бүрэлдэхүүнд бэлчээр тэжээлийн шимт чанараар муу ургамал зонхилох болсон байна. Эндхийн ургамлан нөмрөг сийрэг тарчиг, зүйлийн бүрдэл нь *Salsola collina*, *Salsola palicifolia*, *Chenopodium album*, *Chenopodium aristatum*, *Tribulus terrestris* *Artemisia scoparia* зэрэг цөөн наст ургамлууд ургаж байна.

Амьтны аймаг. Ховор амьтнаас аргаль, янгир, бусад амьтадаас цагаан зээр, үнэг, чоно, говийн болон тал хээрийн усны шувууд нутагладаг. Сансараас авсан гадаргын бүрхэвчийн зургаас үзвэл бараг бүх нутаг нь хээр, харин өмнөд хэсгийг говийн бүс эзэлж байна.

ХОЁР. УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ, АЖИЛЛАХ ГОРИМ, КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын систем

Шивээ-Овоогийн уурхай нүүрсний I, II давхаргыг ашиглаж байна. Энэ хоёр давхарга нь энгийн тогтоцтой 5-7 м зузаан хоосон чулууны үеэр зааглагддаг. Хоёр давхаргын нийлбэр зузаан дунджаар 21-26 м, давхаргууд 6^0 - 8^0 орчим уналтай. Нүүрсний давхаргын ул нь саарал өнгийн алевролит, аргиллит зэрэг чулуулагуудаас үелэн тогтсон байна. Алевролитын эзлэхүүн жин 1.81-2.06 г/см³, дунджаар 1.93 г/см³.

2.1. Уурхайн ажиллах горим

Уурхай нь жилийн турш хоногт 8,5 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллана. Мөн цаг агаарын гэнэтийн тааламжгүй нөхцлөөс болж ажил саатах хоногийг хасаж тооцоолов. Тоног төхөөрөмжийн урсгал болон үндсэн засварын хугацааг тоног төхөөрөмжийн төрөл зүйл, хүчин чадлаас хамааруулан бүтээлийн тооцоонд хасаж өгөв. Төлөвлөгөөнд уурхайн ажиллах хоногийг дараахь байдлаар тогтоов.

Үүнд: Жилийн хоног – 365

Цаг агаарын нөхцлөөс саатах хоног – 5

Хоногт ажиллах ээлжийн тоо – 2

Ээлжийн үргэлжлэх хугацаа – 12 цаг

Баяр ёслолоор амрах хоног – 10 хоног

Уурхайн ажиллах хоног: $365 - 5 - 10 = 350$ хоног болно.

2.2. 2018 оны уулын ажлын төлөвлөгөөний биелэлт /2018.11.01/

2018 онд 2000.0 мян.тн нүүрс олборлон, борлуулах, 8465.5 мян.м³ хөрс хуулах үүнээс тээвэртэй 6417.9 мян.м³, тээвэргүй 2047.6 мян.м³-ын төлөвлөгөөтэй ажиллаж гүйцэтгэлээр 2018 оны 11-р сарын 01-ны байдлаар нүүрс олборлолт 1596.4 мян.тн, борлуулалт 1529.0 мян.тн, нийт хөрс 5259.6 мян.м³ үүнээс тээвэртэй 3808.4 мян.м³, тээвэргүй 1451.2 мян.м³ хөрсний ажил тус тус гүйцэтгэсэн байна. 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 403.6 мян.тн нүүрс олборлон, борлуулж, 6965.1 мян.м³ хөрс хуулж үүний тээвэртэй 4917.5 мян.м³, тээвэргүй 2047.6 мян.м³ тус тус байна.

2019 онд складанд 80.0 мян.тн, карьерт авахад бэлэн 410.0 мян.тн нүүрний нөөцтэй шилжихээр байна.

2.2.1. Тээвэртэй хөрс хуулалт:

Тээвэртэйгээр 6417.9 мян.м³ хөрс хуулахаар төлөвлөсөн үүнээс: Үндсэн хөрс 5010.0 мян.м³, нүүрсний үеүдийн хоорондох завсрын хөрс 1367.9 мян.м³, шимт хөрс 40.0 мян.м³-ыг тус тус хуулахаар ажилласан.

Хөрс хуулалтанд ЭКГ5А, ЭКГ10И шууд утгуурт цахилгаан экскаватор Komatsu 405-6, САТ-773, SHACMAN, Белаз 55тн, Белаз 130тн автосамосвалуудын хослолоор ажиллана.

Үүнд: Үндсэн хөрс

Хайгуулын VII-XIII шугамын хооронд хөрсний 3-н догол, ашиглалтын 3-р амны нүүрс нээхэд ЭКГ10И, ЭКГ5А шууд утгуурт цахилгаан экскаватор, Коматцу HD405-06 /40тн/, САТ-773 /55тн/, Белаз-7555 /55тн/, Белаз-75137 /130тн/, зэрэг автосамосвалуудын хослолоор гадаад болон дотоод овоолго руу 2540.9 мян.м³ хөрсийг зөөвөрлөв.

Завсрын хөрс

0.2-6 метрийн зузаантай 4-н хөрсний судлалыг хайгуулын VII-XIII шугамын хооронд 1267.5 мян.м³ хөрсийг гидроэкскаватор, автосамосвалын хослолоор ангилан ялгаж гадаад овоолго руу зөөвөрлөж гүйцэтгэсэн байна.

Шимт хөрс

2018 онд шинээр овоолго хийх талбай болон түрүүлэх мөргөцгийн ахиулах талбайгаас нийтдээ 40.0 мян.м³ шимт хөрсийг хуулж байгууллагын дотоод овоолгод техникийн нөхөн сэргээлт хийж мөн бусад тохижолтын ажилд гүйцэтгэв.

ЭКГ5А шууд утгуурт экскаваторын хөрсөнд ажиллах бүтээлийн тооцоо

Хүснэгт №07


| № | Үзүүлэлт | Тэмдэглэл | Нэгж | Экскаваторын загвар | |
|----|--------------------------------------------|-----------|---------------------|---------------------|-----------|
| | | | | ЭКГ-5А | |
| 1 | Чулуулгийн ачилтын зэрэглэл, ЕНВ-р | | | III | |
| 2 | Үйлдвэрлэлийн бүтээлтэй цаг | T | цаг | 8.5 | 8.5 |
| 3 | Экскаваторын талын дундаж зай | Lз | км | 2.5 | 2.5 |
| 4 | Чулуулгийн эзлэхүүн жин | | тн/м ³ | 1.92 | 1.92 |
| 5 | Сийрэгжилтийн коэффициент | Kс | | 1.35 | 1.35 |
| 6 | Шанаганы багтаамж | E | м ³ | 5.2 | 5.2 |
| 7 | Шанага дүүргэлтийн коэффициент | Kд | | 1.1 | 1.1 |
| 8 | Шанага дахь хөрсний хэмжээ | Vк | м ³ | 4.2 | 4.2 |
| 9 | Шанага дахь хөрсний эзлэхүүн жин | | тн | 8.1 | 8.1 |
| 10 | Автомашин даац | | тн | 55.0 | 40.0 |
| 11 | Автомашин тэвшний эзлэхүүн /дүүрэн/ | | м ³ | 35.3 | 20.0 |
| 12 | Тэвш ашиглалтын коэффициент | | м ³ | 0.81 | 0.80 |
| 13 | Тэвшинд ачигдах хөрсний эзлэхүүн | | м ³ | 28 | 16 |
| 14 | Тэвшинд ачигдах нүүрсний жин | | тн | 55 | 31 |
| 15 | Нэг автосамосвалыг ачих утгалтын тоо | nk | м ³ | 7 | 4 |
| 16 | Экскаваторын мөчлөгийн хугацаа | t | секунд | 23 | 23 |
| 17 | Автосамосвалыг ачих хугацаа | ta | секунд | 155 | 87 |
| 18 | Автосамосвал ачилтанд орж зогсох хугацаа | tз | секунд | 30 | 30 |
| 19 | Автосамосвалыг хүлээн авах, гаргах хугацаа | txy | секунд | 60 | 60 |
| 20 | Цагийн онолын бүтээл | Qo | м ³ /цаг | 813.91 | 813.91 |
| 21 | Экскаваторын цагийн техникийн бүтээл | Qэц | м ³ /цаг | 419.2 | 325.7 |
| 22 | Автомашин цагийн техникийн бүтээл | Qац | м ³ /цаг | 114.7 | 77.1 |
| 23 | Бүтээл нөлөөлөх хүчин зүйлүүд: | | | | |

| | | | | | |
|----|-----------------------------------------------------------------------------------------|-----|---------------------|-------------|-------------|
| | Техникийн бэлэн байдлын коэффициент | - | - | 0.85 | 0.85 |
| | ТАК (Тээврийн хэрэгсэл, оператор ур чадвар, цаг агаарын хүндрэл, нүүдэл суудал гэх мэт) | - | - | 0.80 | 0.80 |
| 24 | Цагийн бодит бүтээл | Qб | м ³ /цаг | 285.1 | 221.5 |
| 25 | Автомашинь цагийн бодит бүтээл | | м ³ /цаг | 53.4 | 46.9 |
| 26 | Экскаваторын хоногийн бүтээл | txo | м ³ /хон | 4846.0 | 3765.0 |
| 27 | Экскаваторын жилд ажиллах хоног | Тх | хоног | 295 | 295 |
| 28 | Экскаваторын жилийн бүтээл | Qж | мян.м ³ | 1429.6 | 1110.7 |
| 29 | Жилд хуулах хөрсний хэмжээ | Qн | мян.м ³ | 3425.0 | |
| 30 | Инженерийн ажил, машин ачилт | Qi | мян.м ³ | 519.8 | |
| 31 | Экскаваторын тооцооны тоо | Nт | ш | 3.1 | |
| 32 | Экскаваторын бодит тоо | Nб | ш | 4 | |
| 33 | Шаардлагатай автомашины тоо /тех.бүтээл/ | Наб | ш | 4 | 4 |

Зураг-6. ЭКГ5А экскаваторын технологийн үлгэрчилсэн паспорт




Батлав: Ерөнхий менежер Г.Гэрэлхүү Хянасан: _____ ТеБХ-ийн дарга / П.Цэндпүрэв /
Боловруулсан: Технологич инженер Б.Эрдэнэбаяр _____ Тех.ХХАБ-н инженер / С.Анхбаяр /
 _____ УНХ-ийн дарга / Л.Амгалан /

ЭКГ5А №05 ЭКСКАВАТОРЫН 1171-1162-Р ТҮВШИНД ГАРШИЙН НҮҮРС, ХӨРС АЧИХ АЖЛЫН ПАСПОРТ



АЖИЛЛАХ ДАРААЛАЛ АНХААРАХ ЗҮЙЛ

1. ХАБЭА-н заавар журмыг чанд мөрдөж ажиллах.
2. 1169-1159-р түвшинд хөрс, нүүрс ачих ажил гүйцэтгэнэ.
3. Дундаж орлын өргөн Аор=50м, мөргөцөгийн өндөр 6-10м, дундаж фронтын урт LФ=290м, талбайд хөрс, нүүрс ачина.
4. Тухайн орлыг заасан чигийн дагуу ачих ба ажлын хана талд дэвсгэр зурагт заасан замын бермийн хэмжээг баримталж чиг тавьж ажиллана.
5. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хамаарсан буюу төлөвлөгөөт зогсолтуудыг хийх үедээ экскаваторыг бүрэн зогсоож шанага газарт тависан байна !!!
6. Ажлын хана талыг тэгш ба догол, саравч үлдээхгүй авах. / 65 градус /
7. Мөргөцөг дээр чигийг тогтмол тавьж чигийн дагуу авч явах.
8. Мөргөцөгийн ул талбайг тэгшхэн авах ба цэвэрлэж байх
9. Экскаваторын ажлын талбайн бус талд хамгаалалтын далан тогтмол тавьж явах.
10. Экскаваторын тэжээлийн кабелийн байрлалаас шалтгаалж зөв болон буруу талдаа мастерын нарыдаар ачилт хийнэ. (кабелийн тулгуур тогтмол тавь!!!)
11. Автосамосвалд ачилт хийхдээ тогтмол дуут дохиогоор оруулж, гаргах мөн станцаар холбогдсоны дагуу ажиллах.
12. Автосамосвалын тэвш дүүрэн ачих ба экскаваторын утгуур өргөсөн үед утгуурын дор тэгшхэн ухарч орох, оруулах.
13. Бүрэн бус техниктэй ажил гүйцэтгэхийг хориглоно.
14. Ачилт хийх үед автосамосвалын тэвшинд дарахыг хориглоно.
15. Доголын дээд ирмэгээс хамгийн багадаа 5.0 м зайд экскаваторын явах ангийг /гинж/ байрлуулах
16. Чулуулгийн үешил, ан цав, хагарлын бүсийн орчимд экскаваторыг байрлуулахдаа анхаарах.
17. Паспортонд зааснаас өөр хүндрэлтэй нөхцөлд ажиллахад хүрвэл эрсдлийн үнэлгээ хийсний дараа ажилд орох



| тон/тех | экскаваторын параметр | | | | | мөргөцөгийн параметр тэсэлтэстэй | |
|---------|------------------------|-------------------------|--------------------|------------------------|------------------------|----------------------------------|---------------------------|
| | утгах шаж өндөр Ну /М/ | утгах шаж радиус Ру /М/ | Ачих радиус Ра /М/ | Ачих шаж өндөр Нач /М/ | Асгах шаж өндөр На /М/ | доголын өндөр Нд /М/ | ажлын талбайн өргөн В /М/ |
| ЭКГ5А | 10.3 | 14.5 | 12.3 | 6.7 | 4.6-6.5 | 10м> | 45м> |

| № | ТАНИЛЦСАН | | | ТАНИЛЦСАН | | | ШИВЭЭ-ОВОО ХУВЬЦААТ КОМПАНИ | | | |
|---|---------------|------------|-------|-----------------|------------|-------|--------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|--------|------------|
| | Мастер | Гарын үсэг | Огноо | Экс.р машинч | Гарын үсэг | Огноо | Хэлтэс | Масшта | | |
| 1 | П.Ганбаяр | | | Г.Энхболд | | | ЭКГ5А №05 ЭКСКАВАТОРЫН 1171-1162-Р ТҮВШИНД ГАРШИЙН НҮҮРС, ХӨРС АЧИХ АЖЛЫН ПАСПОРТ | Хэлтэс | 1:5000 | |
| 2 | Б.Энхбат | | | Я.Хайдав | | | | Технологи бодлого хэлтэс | | |
| 3 | Ю.Алтан-Оргил | | | Ю.Хатанбаатар | | | | Хуудас | | Бүх хуудас |
| 4 | Э.Бат-Эрдэнэ | | | Б.Амгаланбаатар | | | | | | |
| - | - | | | | | | | | | |

ЭКГ10И шууд утгуурт экскаваторын бүтээлийн тооцоо

Хүснэгт №08

| № | Үзүүлэлт | Тэмдэглэл | Нэгж | Экскаваторын загвар |
|----|-----------------------------------------------------------------------------------------|-----------|---------------------|------------------------|
| | | | | ЭКГ10И |
| 1 | Чулуулгийн ачилтын зэрэглэл, ЕНВ-р | | | III |
| 2 | Үйлдвэрлэлийн бүтээлтэй цаг | T | цаг | 8.5 |
| 3 | Экскаваторын талын дундаж зай | Lз | км | 1.7 |
| 4 | Чулуулгийн эзлэхүүн жин | | тн/м ³ | 1.92 |
| 5 | Сийрэгжилтийн коэффициент | Kc | | 1.35 |
| 6 | Шанаганы багтаамж | E | м ³ | 10 |
| 7 | Шанага дүүргэлтийн коэффициент | Kд | | 1.1 |
| 8 | Шанага дахь хөрсний хэмжээ | Vk | м ³ | 8.1 |
| 9 | Шанага дахь хөрсний эзлэхүүн жин | | тн | 15.6 |
| 10 | Автомашин даац | | тн | 130.0 |
| 11 | Автомашин тэвшний эзлэхүүн /дүүрэн/ | | м ³ | 84.0 |
| 12 | Тэвш ашиглалтын коэффициент | | м ³ | 0.78 |
| 13 | Тэвшинд ачигдах хөрсний эзлэхүүн | | м ³ | 66 |
| 14 | Тэвшинд ачигдах нүүрсний жин | | тн | 126 |
| 15 | Нэг автосамосвалыг ачих утгалтын тоо | nk | м ³ | 8 |
| 16 | Экскаваторын мөчлөгийн хугацаа | t | секунд | 30.5 |
| 17 | Автосамосвалыг ачих хугацаа | ta | секунд | 245 |
| 18 | Автосамосвал ачилтанд орж зогсох хугацаа | tz | секунд | 30 |
| 19 | Автосамосвалыг хүлээн авах, гаргах хугацаа | txy | секунд | 60 |
| 20 | Цагийн онолын бүтээл | Qo | м ³ /цаг | 1180.33 |
| 21 | Экскаваторын цагийн техникийн бүтээл | Qэц | м ³ /цаг | 703.6 |
| 22 | Автомашин цагийн техникийн бүтээл | Qац | м ³ /цаг | 233.4 |
| 23 | Бүтээл нөлөөлөх хүчин зүйлүүд: | | | |
| | Техникийн бэлэн байдлын коэффициент | - | - | 0.85 |
| | ТАК (Тээврийн хэрэгсэл, оператор ур чадвар, цаг агаарын хүндрэл, нүүдэл суудал гэх мэт) | - | - | 0.80 |

| | | | | |
|----|---------------------------------------------|-----|--------|--------|
| 24 | Цагийн бодит бүтээл | Qб | м³/цаг | 478.4 |
| 25 | Автомашины цагийн бодит бүтээл | | м³/цаг | 124.7 |
| 26 | Экскаваторын хоногийн бүтээл | txo | м³/хон | 8133.2 |
| 27 | Экскаваторын жилд ажиллах хоног | Tx | хоног | 295 |
| 28 | Экскаваторын жилийн бүтээл | Qж | мян.м³ | 2399.3 |
| 29 | Жилд хуулах хөрсний хэмжээ | Qн | мян.м³ | 2000.0 |
| 30 | Инженерийн ажил, машин ачилт | Qi | мян.м³ | 0.0 |
| 31 | Экскаваторын тооцооны тоо | Nт | ш | 0.83 |
| 32 | Экскаваторын бодит тоо | Nэб | ш | 1 |
| 33 | Шаардлагатай автомашины тоо /тех.бүтээл/ | Наб | ш | 3 |

Гидроэкскаваторын завсрын хөрсөнд ажиллах бүтээлийн тооцоо

Хүснэгт №09


| № | Үзүүлэлт | Тэмдэглэл | Нэгж | Экскаваторын загвар |
|----|--------------------------------------|-----------|--------|------------------------|
| | | | | DX500 3/хөрс |
| 1 | Чулуулгийн ачилтын зэрэглэл, ЕНВ-р | | | IV |
| 2 | Үйлдвэрлэлийн бүтээлтэй цаг | T | цаг | 8.5 |
| 3 | Экскаваторын талын дундаж зай | Lз | км | 2.5 |
| 4 | Чулуулгийн эзлэхүүн жин | | тн/м³ | 1.92 |
| 5 | Сийрэгжилтийн коэффициент | Kс | | 1.35 |
| 6 | Шанаганы багтаамж | E | м³ | 3.4 |
| 7 | Шанага дүүргэлтийн коэффициент | Kд | | 1.1 |
| 8 | Шанага дахь хөрсний хэмжээ | Vк | м³ | 2.8 |
| 9 | Шанага дахь хөрсний эзлэхүүн жин | | тн | 5.3 |
| 10 | Автомашины даац | | тн | 55.0 |
| 11 | Автомашины тэвшний эзлэхүүн /дүүрэн/ | | м³ | 35.2 |
| 12 | Тэвш ашиглалтын коэффициент | | м³ | 0.81 |
| 13 | Тэвшинд ачигдах хөрсний эзлэхүүн | | м³ | 28 |
| 14 | Тэвшинд ачигдах нүүрсний жин | | тн | 55 |
| 15 | Нэг автосамосвалыг ачих угталтын тоо | nk | м³ | 10 |
| 16 | Экскаваторын мөчлөгийн хугацаа | t | секунд | 23 |

| | | | | |
|----|-----------------------------------------------------------------------------------------|-----|--------|-------------|
| 17 | Автосамосвалыг ачих хугацаа | ta | секунд | 236 |
| 18 | Автосамосвал ачилтанд орж зогсох хугацаа | tз | секунд | 30 |
| 19 | Автосамосвалыг хүлээн авах, гаргах хугацаа | txү | секунд | 60 |
| 20 | Цагийн онолын бүтээл | Qо | м³/цаг | 532.17 |
| 21 | Экскаваторын цагийн техникийн бүтээл | Qэц | м³/цаг | 314.1 |
| 22 | Автомашинны цагийн техникийн бүтээл | Qац | м³/цаг | 119.9 |
| 23 | Бүтээл нөлөөлөх хүчин зүйлүүд: | | | |
| | Техникийн бэлэн байдлын коэффициент | - | - | 0.80 |
| | ТАК (Тээврийн хэрэгсэл, оператор ур чадвар, цаг агаарын хүндрэл, нүүдэл суудал гэх мэт) | - | - | 0.75 |
| 24 | Цагийн бодит бүтээл | Qб | м³/цаг | 188.4 |
| 25 | Автомашинны цагийн бодит бүтээл | | м³/цаг | 80.5 |
| 26 | Экскаваторын хоногийн бүтээл | txо | м³/хон | 3203.5 |
| 27 | Экскаваторын жилд ажиллах хоног | Tx | хоног | 329 |
| 28 | Экскаваторын жилийн бүтээл | Qж | мян.м³ | 1053.9 |
| 29 | Жилд хуулах хөрсний хэмжээ | Qн | мян.м³ | 1085.0 |
| 30 | Инженерийн ажил, машин ачилт | Qi | мян.м³ | 0.0 |
| 31 | Экскаваторын тооцооны тоо | Nт | ш | 1.0 |
| 32 | Экскаваторын бодит тоо | Nэб | ш | 2 |
| 33 | Шаардлагатай автомашинны тоо /тех.бүтээл/ | Наб | ш | 3 |

Зураг-7. Гидроэкскаваторуудын ажиллах үлгэрчилсэн паспорт

Батлав: Ерөнхий менежер Г.Гэрэлхүү Хянасан: ___ ТеБХ-ийн дарга / П.Цэндпүрэв /
 Боловсруулсан: Технологич инженер Б.Эрдэнэбаяр ___ Тех.ХХАБ-н инженер / С.Анхбаяр /
 ___ УНХ-ийн дарга / Л.Амгалан /

DX500LCA гидроекскаваторын нүүрсний мөргөцөгт ухаж ачих паспорт



Анхаарах зүйлс:

- Экскаваторын оператор сохор талдаа ачихгүй байх, өөрийн хажуу талаас ачихгүй байх
- Мөргөцөгийн ул талбайг тэгшхэн авах ба цэвэрлэж байх
- Доголын дээд ирмэгээс хамгийн багадаа 2.5м зайд экскаваторын явах ангийг /гинж/ байрлуулах
- Ачилтанд орох болон гарахдаа дуут дохио, станцаар холбогдсоны дагуу хөдлөх
- Автосамосвалын опеаотор экскаваторын оператор утгуур өргөсөн үед утгуурын дор тэгшхэн ухарч орох
- Чулуулгийн үешил, ан цав, хагарлын бүсийн орчимд экскаваторыг байрлуулахдаа анхаарах
- Паспортод зааснаас өөр хүндрэлтэй нөхцөлд ажиллахад хүрвэл эрсдлийн үнэлгээ хийсний дараа ажилд орох

| Танилцсан | |
|-----------|------------|
| Мастер | Гарын үсэг |
| | |
| | |
| | |
| | |


| Танилцсан | |
|-----------|------------|
| Оператор | Гарын үсэг |
| | |
| | |
| | |
| | |

2017.12.18

Зураг-8. Дугуйт ачигчийн ажиллах үлгэрчилсэн паспорт




| | | | |
|----------------|---------------------------------|------------|-------------------------------------------------------------------------------|
| Батлав: | Ерөнхий менежер Г.Гэрэлхүү | Хянасан: | _____ ТеБХ-ийн дарга / П.Цэндпүрэв / |
| Боловсруулсан: | Технологич инженер Б.Эрдэнэбаяр | Танилцсан: | _____ ТХХАБЭА-н инженер / С.Анхбаяр / _____ УНХ-ийн дарга / Д.Баяржаргал / |

Дугуйт ачигчийн ажиллах үлгэрчилсэн паспорт



Анхаарах зүйлс:

- Экскаваторын оператор сохор талдаа ачихгүй байх, өөрийн хажуу талаас ачихгүй байх
- Мөргөцөгийн ул талбайг тэгшхэн авах ба цэвэрлэж байх
- Доголын дээд ирмэгээс хамгийн багадаа 2м зайд экскаваторын явах ангийг /гинж/ байрлуулах
- Ачилтанд орох болон гарахдаа дуут дохио, станцаар холбогдсоны дагуу хөдлөх
- Автосамосвалын оператор нь экскаваторын операторыг утгуур өргөсөн үед утгуурын дор тэгшхэн ухарч орох
- Чулуулгийн үешил, ан цав, хагарлын бүсийн орчимд экскаваторыг байрлуулахдаа анхаарах
- Паспортод зааснаас өөр хүндрэлтэй нөхцөлд ажиллахад хүрвэл эрсдлийн үнэлгээ хийсний дараа ажилд орох



| Дугуйт ачигчийн техникийн үзүүлэлт /шанаганы багтаамж, м3 / | | | |
|-------------------------------------------------------------|-------|--------|-----------------|
| ZL50CN | DL550 | WA-600 | Гүрээсийн ачигч |
| 3.0 | 5.4 | 6.3 | 3.0 |

| ТАНИЛЦСАН | | | | ШИВЭЭ-ОВОО ХУВЬЦААТ КОМПАНИ | | |
|-----------|-------------|------------|-------|---------------------------------------------|--------------------------|------------|
| № | Мастер | Гарын үсэг | Огноо | Дугуйт ачигчийн ажиллах үлгэрчилсэн паспорт | Хэлтэс | Масштаб |
| 1 | П.Ганбаяр | | | | Технологи бодлого хэлтэс | 1:1000 |
| 2 | Б.Энхбат | | | | Хуудас | Бүх хуудас |
| 3 | Б.Дашдаваа | | | | 2018.10.24 | |
| 4 | Т.Баасанжав | | | | | |
| 5 | Б.Балжинням | | | | | |

2.2.2. Тээвэргүй хөрс хуулалтанд:

Хайгуулын VII-XI шугамын хооронд 1786.2 мян.м³ хөрс хуулж 1849.2 мян.м³ дахин шидэлтийн ажлыг ЭШ-25/90, ЭШ-11/70 алхагч экскаваторуудаар тус тус гүйцэтгэсэн байна.

Нийт тээвэргүйгээр 2047.6 мян.м³ хөрс хуулж, дахин шидэлтээр 1899.2 мян.м³ уулын ажил гүйцэтгэнэ.

**Тээвэргүй хөрс хуулалтанд ажиллаж байгаа техникүүдийн хүчин чадал,
ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Хүснэгт №10

| № | Үзүүлэлтүүд | Х.нэгж | ЭШ-25/90 | ЭШ-11/70 |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|------------|----------|
| 1. | Шанаганы багтаамж | м ³ | 25 | 11 |
| 2. | Сумны урт | м | 91 | 70 |
| 3. | Сумны үзүүрийн максимум ачаалал | кн(тс) | 775(77) | 279 |
| 4. | Сумны налуугийн өнцөг | град | 32 | 30 |
| 5. | Утгалтын хугацаа 10сек, эргэлтийн өнцөг 120о, чулуулгийн хатуулаг IV категори, утгалтын гүн болон асгалтын өндөр максимумын 3/2-оос ихгүй үед ажлын циклийн үргэлжлэх хугацаа | с | 60 | 52.7 |
| 6. | Хамгийн их утгалтын радиус | м | 85.4 | 66.5 |
| 7. | Утгалтын хамгийн их гүн | м | 47 | 35.0 |
| 8. | Асгалтын хамгийн их радиус | м | 85.4 | 66.5 |
| 9. | Асгалтын хамгийн их өндөр | м | 37.5 | 27.5 |
| 10. | Их биений арын хэсгийн эргэлтийн радиус | м | 19.15 | 15.0 |
| 11. | Эргэлтийн тавцангийн доорхи завсар | м | 1.614 | 1.28 |
| 12. | Шанаганы өргөгдөх хурд | м/с | 2.5 | |
| 13. | Өргөлтийн хамгийн их хүч | мн(тс) | 1.373(140) | |
| 14. | Таталтын хамгийн их хүч | мн(тс) | 1.521(155) | |
| 15. | Тросснуудын тоо ширхэг болон диаметр өргөх лебёдкийн | мн(тс) | 70x2 | 66x2 |
| 16. | Өргөх болон татах лебёдкийн барабан (дамар)-ы диаметр | мм-ш | 2.0 | 2.0 |
| 17. | Алхах үеийн тулгуурын башмакны газрын гадаргад үзүүлэх дундаж хувийн даралт | МПа(кгс/с м ²) | 0.216 | 0.166 |
| 18. | Утгалтын үеийн тулгуур рамын газрын гадаргад үзүүлэх дундаж хувийн даралт | МПа(кгс/с м ²) | 0.105 | 0.097 |
| 19. | Алхах үед туулах хамгийн их өгсүүр болон уруугийн хэмжээ | град | 7 | 7 |
| 20. | Алхалтын үеийн зөвшөөрөгдөх максимум өнцгийн хэмжээ | град | 3 | 3 |

| | | | | |
|-----|------------------------------------------------------|---------------------|---------|------|
| 21. | Утгалтын үеийн зөвшөөрөгдөх максимум өнцгийн хэмжээ | град | 2 | 2 |
| 22. | Алхалтын хурд | м/цаг | 100-120 | 200 |
| 23. | Алхмын хэмжээ | м | 2.2 | 1.6 |
| 24. | Тулгуур рамын диаметр | м | 15.3 | 9.7 |
| 25. | Хувиргах агрегатын синхрон хөдөлгүүрийн чадал | кВт | 2500 | 1460 |
| 26. | Өргөх механизмын хөдөлгүүрүүдийн тоо болон чадал | кВт | 1120x2 | |
| 27. | Татах механизмын хөдөлгүүрүүдийн тоо болон чадал | кВт | 1120x2 | |
| 28. | Эргэлтийн механизмын хөдөлгүүрүүдийн тоо болон чадал | кВт | 250x4 | |
| 29. | Алхах механизмын хөдөлгүүрүүдийн тоо болон чадал | кВт | 630x2 | |
| 30. | Тэжээх гүйдлийн хүчдэл | кВт | 6 | 6 |
| 31. | I категорийн чулуулагт ажиллах тооцооны бүтээл | м ³ /цаг | 1200 | 540 |
| 32. | Экскаваторын ажлын масс | тн | 1922 | 767 |
| 33. | Экскаваторын ажлын зөвшөөрөгдөх температурын хязгаар | ос | 40 | 40 |

ЭШ25/90 алхагч экскаваторын бүтээлийн тооцоо

Алхагч экскаваторын ээлжийн үргэлжлэх хугацааг 10 цагаар тооцов.


Хүснэгт №11

| № | Үзүүлэлт | Нэгж | Драглайн | |
|----|------------------------------------------------------------|---------------------|----------|-------|
| 1 | Экскаваторын загвар | | ЭШ-25/90 | |
| 2 | Чулуулгийн ачилтын зэрэглэл ЕНВ-р | | II | III |
| 3 | Чулуулгийн эзлэхүүн жин, γ | тн/м ³ | 1.92 | 1.92 |
| 4 | Сийрэгжилтийн коэффициент, K _{хс} | | 1 | 1.35 |
| 5 | Шанаганы багтаамж, E | м ³ | 25 | 25 |
| 6 | Шанага дүүргэлтийн коэффициент K _д | | 1.2 | 1.2 |
| 7 | Шанага дахь хөрсний хэмжээ, V _к | м ³ | 30 | 22.2 |
| 8 | Шанага дахь хөрсний хэмжээ, (эзлэхүүн жин) | тн | 57.6 | 42.6 |
| 9 | Экскаваторын мөчлөгийн хугацаа | секунд | 80 | 80 |
| 10 | Цагийн онолын бүтээл | м ³ /цаг | 1350.0 | 999.0 |
